



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/154

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйл, 19 дүгээр зүйлийн 19.2, 23 дугаар зүйлийн 23.3, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 33 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргах журам"-ыг нэгдүгээр, "Галын аюулгүй байдлын маягтын загвар"-ыг хоёрдугаар, "Барилгын зураг төсөлд хяналт хийсэн тухай дүгнэлтийн маягтын загвар"-ыг гуравдугаар, "Барилгын зураг төсөл хяналтын болон барилга хүлээн авах комисст ажиллах чиг үүргийн хуваарь"-ийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга (хурандаа Ж.Чүлтэмсүрэн), Гал түймэртэй тэмцэх газар (хурандаа Ц.Нямбаяр), галын аюулгүй байдлын дүгнэлтийн маягт хэвлүүлэх, бүртгэх, хадгалах, тооцоо хийж ажиллахыг Ар тал, санхүү, хөрөнгө оруулалтын газар (хурандаа Я.Гантөмөр)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/02 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Г.АРИУНБУЯН

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн
1/154 дугаар тушаалын нэгдүгээр хэвсрэлт



ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ ГАРГАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Галын аюулгүй байдлыг хангах, гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх чиглэлээр Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-6.1.4, 19 дүгээр зүйлийн 19.2, 23 дугаар зүйлийн 23.3, 23.4, Аюултай ачаа тээвэрлэх журмын 3 дугаар зүйлийн 3.5, Монгол Улсын Шадар Сайдын 2017 оны 61 дүгээр тушаалын дагуу галын аюулгүй байдлын дүгнэлт гаргах үйл ажиллагааг, энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргах.

2.1. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн хүсэлт, холбогдох баримт бичгийн дагуу гал түймрийн улсын хяналтын /ахлах/ байцаагчийн шалгалтын дүнг үндэслэн Галын аюулгүй байдлын дүгнэлтийг гал түймрийн онц аюултай барилга байгууламжид 1 жилийн хугацаатай, гал түймрийн аюултай 1 дүгээр зэргийн барилга байгууламжид 2 жилийн хугацаатай, гал түймрийн 2, 3 дугаар зэргийн барилга байгууламжид 3 жилийн хугацаатай тус тус гаргана.

2.2. Галын аюулгүй байдлын дүгнэлт авахад аж ахуйн нэгж, байгууллага нь хүсэлт, Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, барилга байгууламжийг ашиглалтад оруулсан тухай Улсын комиссын дүгнэлт, иргэн нь хүсэлт, иргэний үнэмлэхийн хуулбар, түрээсийн барилга байгууламж бол гэрээ зэргийг тухайн нутаг дэвсгэрийн Онцгой байдлын байгууллагад хүргүүлнэ.

2.3. Дүгнэлт гаргасан Гал түймрийн улсын хяналтын /ахлах/ байцаагч нь үнэт цаасан дүгнэлтийн хэвлэмэл маягтад гарын үсэг зурж тэмдэг дарах бөгөөд тухайн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга баталгаажуулна.

2.4. Галын аюулгүй байдлын дүгнэлтийн хугацаа дууссан тохиолдолд гал түймрийн улсын хяналтын байцаагчийн шалгалтын дүнг үндэслэн Онцгой байдлын байгууллагын эрх бүхий албан тушаалтан шинээр гаргана.

2.5. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс ирүүлсэн хүсэлт, холбогдох баримт бичгийг үндэслэн Онцгой байдлын байгууллагын эрх бүхий албан тушаалтан ажлын 10 хүртэлх хоногт хяналт шалгалтыг зохион байгуулж, Галын аюулгүй байдлын дүгнэлт олгох боломжтой эсэхийг шийдвэрлэнэ.

Гурав. Барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, хийц бүтээц, цахилгаан эх үүсвэрийн шугам сүлжээг өөрчлөх, засварлах, болон хийн хангамжийн угсралт ашиглалтад дүгнэлт гаргах.

3.1. Барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, хийц бүтээц, цахилгааны эх үүсвэрийн шугам сүлжээг өөрчлөх, засварлах, хийн хангамж угсралтад гал түймрийн улсын хяналтын /ахлах/ байцаагч нь Галын аюулгүй байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.4, 21.6-т заасан барилга байгууламжийн зураг төсөлд галын аюулгүй байдлын дүрэм норм, стандартын шаардлагыг хангасан эсэхэд хяналт тавьж, дүгнэлт гаргана.

3.2. Зураг төслийг зөвшилцөхөд тухай байгууллага, иргэний хүсэлт, газар олголын схем, захирамж, техникийн нөхцөлүүд /Цахилгаан, цэвэр бохир усны техникийн нөхцөл, дулааны техникийн нөхцөл холбооны техникийн нөхцөл, газар

эзэмших, өмчлөх эрхийн гэрчилгээ, геологийн дүгнэлт, архитектур төлөвлөлтийн даалгавар, барилгын зураг төслийн байгууллагын тусгай зөвшөөрөл, Барилгын зураг төслийн иж бүрдэл /Архитектур төлөвлөлт, бүтээц хийц, цэвэр бохир ус, халаалт салхивч, холбоо дохиолол, инженерийн хангамж /гадна ус, цахилгаан, техник технологийн шийдэл, тэдгээрийн тооцооны үндэслэл, загвар зураг зэрэг материалаас бүрдсэн барилгын зураг төслийг Онцгой байдлын байгууллагын эрх бүхий албан тушаалтан нь батлагдсан чиг үүрэг, ажлын хуваарийн дагуу барилгын зураг төслийг хянан баталгаажуулж, галын аюулгүй байдлын шаардлага хангасан эсэхэд дүгнэлт гаргана.

3.3. Барилгын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн иж бүрэн зураг төслийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 20 хоногт, 10.1.4-т заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн иж бүрэн зураг төслийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 хоногт, 10.1.3-т заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн иж бүрэн зураг төслийг ажлын 5 хоногт, 10.1.1, 10.1.2-т заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн иж бүрэн зураг төслийг 1-3 хоногт багтаан хянана. Мөн хуулийн 32 дугаар зүйлийн 32.15.-т заасан барилга байгууламжийн иж бүрэн зураг төслийг хянахад ажлын хэсэг томилон ажиллуулж болно.

3.4. Барилга байгууламжийн зураг төсөл нь зургийн нүүр хуудас дээр дарсан "ХЯНАСАН" гэсэн тусгай тэмдэг, Гал түймрийн улсын хяналтын /ахлах/ байцаагчийн холбогдох хуудас дээр дарсан тэмдэг, гарын үсэг, Улсын байцаагчийн зураг төсөл хянасан дүгнэлтийн хамт баталгаажна.

3.5. Онцгой байдлын байгууллага нь барилгын зураг төслийн галын аюулгүйн дүрэм, норм, стандартын шаардлагыг хангуулсан байдалд хяналт тавьж, дүгнэлт гаргасан талаар цахим мэдээллийн санг бүрдүүлж, дүнг тайланд тусгана.

Дөрөв. Гал түймрээс хамгаалах техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд дүгнэлт гаргах.

4.1. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын барилга байгууламж, галын аюултай бүтээгдэхүүн гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж, /гал унтраах автомат болон дохиоллын систем, утаа зайлуулах систем, усан хангамж/ анхан шатны багаж хэрэгсэл, бодис материал зэргийг байрлуулан ашиглахад Галын аюулгүй байдлын тухай хуулийн 4, 16, 17, 19, 23, Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 49 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтыг тус тус үндэслэн галын аюулгүй байдлын дүгнэлт гаргана.

4.2. Гал түймрээс хамгаалах техник тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд гаргах дүгнэлтийг Онцгой байдлын байгууллагын гал түймрийн улсын хяналтын /ахлах/ байцаагч үзлэг шалгалт хийсэн дүнг үндэслэн ажлын 10 хоногт багтаан гаргана.

4.3. Гал түймрээс хамгаалах техник тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд гаргах дүгнэлтийг хяналт шалгалт хийсэн гал түймрийн улсын хяналтын /ахлах/ байцаагч, Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 93 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан эрх зүйн баримт бичгийн хэвлэмэл хуудсан дээр 1 жилийн хугацаатай бичиж олгох бөгөөд хугацаа дууссан тохиолдолд дахин хяналт шалгалт хийж, шинээр гаргана.

4.4. Онцгой байдлын байгууллага галын аюулгүй байдлын дүгнэлт гаргасан талаар цахим мэдээллийн санг бүрдүүлж, дүнг тайланд тусгана.

Тав. Галын аюулгүй байдлын дүгнэлтийг цуцлах, хүчингүй болгох.

5.1. Галын аюултай тэсэрч дэлбэрэх бодис материал хадгалах, ашиглах, үйлдвэрлэх борлуулах, тээвэрлэхэд болон Галын онц аюултай, гал түймрийн 1, 2, 3 дугаар зэргийн барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, хийц бүтээц,

цахилгааны эх үүсвэрийн шугам сүлжээг өөрчлөх, засварлахад олгосон дүгнэлтийг гал түймрийн улсын хяналтын /ахлах/ байцаагчийн албан ёсны шаардлагыг биелүүлээгүй, үүний улмаас гал түймрийн зөрчил гаргасан, галын аюулгүй байдлын шаардлага, дүрэм норм, стандартыг зөрчсөн тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу цуцалж болно.

5.2. Цуцлагдсан, хүчингүй болгосон дүгнэлтийг сэргээж сунгахгүй. Тухайн байгууллага зөрчлийг арилгаж хүсэлт гаргасан тохиолдолд гал түймрийн улсын хяналтын /ахлах/ байцаагч дахин хяналт шалгалт хийж, галын аюулгүй байдлын дүгнэлтийг шинээр гаргана.

5.3. Галын аюулгүй байдлын дүгнэлт нь галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, норм дүрэм зөрчигдсөнөөс үүдэн гарсан зөрчлийн болон эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

Зургаа. Галын аюулгүй байдлын дүгнэлт хэвлүүлэх, санхүүгийн тайлан гаргах тооцох.

6.1. Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргахад Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан хязгаарт багтаан Засгийн газраас тогтоосон хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана.

6.2. Галын аюулгүй байдлын дүгнэлтийн маягт хуудсыг Онцгой байдлын ерөнхий газрын Санхүү, хангалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж батлагдсан загварын дагуу хэвлүүлнэ.

6.3. Галын аюулгүй байдлын дүгнэлтийн хэвлэмэл маягт нь тусгай дугаар, нууцлал бүхий тэмдэг баталгаажсан байна.

6.4. Галын аюулгүй байдлын дүгнэлтийн хэвлэмэл маягт хуудас хэвлүүлэх зардлыг Онцгой байдлын ерөнхий газрын жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

6.5. Галын аюулгүй байдлын дүгнэлт, барилгын зураг төсөл хянасан дүгнэлт гаргуулах зорилгоор тушаах тэмдэгтийн хураамжийг "Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль"-ийн 42 дугаар зүйлийн 42.3-т заасны дагуу Улсын болон орон нутгийн төсвийн дансанд тушаана.

6.6. Санхүүгийн мэдээ, тайланг төв орон нутгийн Онцгой байдлын байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, Сангийн яам, Татварын ерөнхий газраас батлан гаргасан зөвлөмж маягтын дагуу гаргаж, тухайн жилийн 7 дугаар сарын 01, дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор тус тус Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлнэ.

Долоо. Хяналт, хариуцлага.

7.1. Галын аюулгүй байдлын дүгнэлт олгох, сунгах, хүчингүй болгох үйл ажиллагаанд Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж хяналт тавьж ажиллана.

7.2. Энэхүү журмыг зөрчиж, Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---



Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2021 он ⁰⁷ дугаар сарын ⁰⁷ ний өдрийн
дугаар тушаалын 2 дугаар хавсралт
МНСД

ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ

Дугаар

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр:

Хаяг:

Ажлын байрны зориулалт, үйл ажиллагааны чиглэл:

.....

Барилга байгууламжад гал унтраах товог төхөөрөмж /гал унтраах автомат болон
дохноллын систем, утаа зайлуулах систем, усан хангамж/ анхан шатны багаж хэрэгсэл,
бодис материал зэргийг байрдуулан ашиглахад энэхүү дүгнэлтийг олгоно.

/Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 33.1-4/
/Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6.1.3, 19.2, 23.28 23.3/

Олгосон: он сар өдөр

Хүчинтэй хугацаа: он сар өдөр хүртэл

Дүгнэлт олгосон:

..... аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/
дарга цолтой

Дүгнэлт гаргасан:

..... аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/
Гал түүмрийн улсын хяналтын бандцагч: цолтой

ГЭМДЭГ ДАРГА



Шалгалт хийсэн тухай тэмдэглэл

№	ШАЛГАХ ЧИГЛЭЛ	ХАМРАХ ХҮРЭЭ	ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН	СТАНДАРТ ДҮРЭМ НОРМЫН ШААРДЛАГА	ШААРДЛАГА ХАНГАСАН ЭСЭХ
1.	Барилга байгууламжид байгаа гал унтраах болон галаас сэргийлэх тоног төхөөрөмж	Гал унтраах автомат тоног төхөөрөмж			
		Галын дохиололын систем			
		Утаа зайлуулах систем			
		Аврах хэрэгсэл			
2.	Гал унтраах анхан шанты багаж хэрэгсэл	Гал унтраагуур			
		Галын сараач			
		Бусад			
3.	Галаас хамгаалах болон гал унтраах бодис материал	Гал унтраах усан хангамж			
		Гал унтраах хөөс			
		Галаам хамгаалах түрхлэг/ нэвчилгээ			
4.	Бусад	Авралтын зам гарцын тэмдэг, тэмдэглэгээ			
		Бусад			

Шалгасан:

Гал түймрийн улсын хяналтын байцаагч:

..... цолтой



Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2021 оны 07 дугаар сарын 07-ий өдрийн
дугаар тушаалын 2 дугаар хэсгээрлт

ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ

Дугаар

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр:

Хаяг:

Ажлын байрны зориулалт, үйл ажиллагааны чиглэл:

.....

Барилга байгууламжад гал унтраах тоног төхөөрөмж, гал унтраах автомат болон
дохиоллын систем, утаа зайлуулах систем, усан хангамж/ анхан шатны багаж хэрэгсэл,
бодис материал зэргийг байрлуулан ашиглахад энэхүү дүгнэлтийг олгоно.

/Улсын гэмдэлтийн хураамжийн тухай хуулийн 33.1-4/
/Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6.1.3, 19.2, 23.28 23.3/

Олгосон: он сар өдөр

Хүчинтэй хугацаа: он сар өдөр хүртэл

Дүгнэлт олгосон:

..... аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/
дарга цолтой

Дүгнэлт гаргасан:

..... аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/
Гал түймрийн улсын хяналтын бонцрагч: цолтой

ГЭМДЭГ ДАРГА



САНАМЖ

Галын аюулгүй байдлын дүгнэлтийг үйлчилгээний танхимд хүний нүдэнд харагдахуйц газар байрлуулсан байна.

Галын аюулгүй байдлын дүгнэлт нь үнэт цаас учраас үрэгдүүлж, гэмтээлгүй хадгалахаас гадна хувилж, олшруулж, хуурамчаар үйлдвэрлэсэн болон бусдад түрээслэх, худалдсан тохиолдолд хариуцлага хүлээлгэнэ.

Галын аюулгүй байдлын дүгнэлт нь банкны зээлийн баталгаа, барьцаа болохгүй.

Галын аюулгүй байдлын дүгнэлт нь Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, түүнтэй нийцүүлэн гаргасан норм, дүрэм, стандартыг зөрчсөн тохиолдолд Онцгой байдлын байгууллагын эрх бүхий албан тушаалтан хураан авах, цуцлах эрхтэй.

Галын аюулгүй байдлын дүгнэлтийн хугацаа дууссанаас хойш 1 сарын хугацаанд дахин сунгуулах.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн
 А/154 дугаар тушаалын туравдугаар хавсралт



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
 ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
 БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨЛД ХЯНАЛТ ХИЙСЭН
 ТУХАЙ ДҮГНЭЛТ

___ оны ___ дугаар сарын ___ № ___ Улаанбаатар хот

Нэг. Барилга байгууламжийн зураг төслийн мэдээлэл

1. Барилга байгууламжийн байршил:
2. Зургийн шифр, зураг төслийн компани:
3. Барилга байгууламжийн зориулалт:
4. Барилга байгууламжийн багтаамж, куб.м
5. Барилга байгууламжийн давхар, талбай:
6. Галд тэсвэршилтийн зэрэг: төлөвлөсөн
7. Үйлдвэрлэлийн ангилал:
8. Барилгын үүргийн галын аюулын анги:
9. Зургийн иж бүрдэл:
10. Галын аюулгүй байдлыг хангах чиглэлээр:
 - 10.1. Гал унтраах автомат тоног төхөөрөмж: хуудас дугаар
 - 10.2. Галын дохиоллын зураг: хуудас дугаар
 - 10.3. Гал унтраах гадна усан хангамж: хуудас дугаар

Хоёр. Барилга байгууламжийн зураг төслийн галын аюулгүй байдалд хяналт шалгалт хийсэн тэмдэглэл

№	Хяналт шалгалт хийсэн тэмдэглэл	Илэрсэн зөрчил	Стандарт норм норматив зөрчигдсөн заалт	Биелэлт
1	Ерөнхий төлөвлөгөө, галын аюулгүйн зай хэмжээ	Барилга хоорондын зай		
		Галын автомашины зам		
		Үер усны хамгаалалт		
	Архитектур төлөвлөлт, байгуулалт, хийц бүтээцийн шийдэл	Барилгын материал		
		Гадна шат		
		Дотор шат, шатны хонгил, цахилгаан шат		
		Галаас хамгаалах хаалт, хаалга		

2		Галаас тусгаарлах зааг, өрөө тасалгаа		
		Дээвэр		
		Газар доорх давхрын зориулалт		
		Авралтын зам гарц		
3	Гал түймрээс хамгаалах техник, төхөөрөмж тоног	Гал унтраах автомат тоног төхөөрөмж		
		Гал гарсан тухай зарлан мэдээлэх систем		
		Галын дохиоллын систем /утаа, дулааны мэдээлэгч/		
4	Гал унтраах усан хангамж	Гадна усан хангамж		
		Дотор усан хангамж		
		Галын усан сан		
5	Агааржуулалт, утаа зайлуулах систем	Утаа зайлуулах систем		
		Агаар өгөх		
6	Цахилгаан сүлжээ, хэрэгсэл ерөнхий цахилгаан	Цахилгаан утасны сонголт		
		Цахилгаан тоног төхөөрөмжийн сонголт		
		Хуваарилах самбар		
		Галаас хамгаалах төхөөрөмж		
		Зам гарцын гэрлэн тэмдэг, тэмдэглэгээ		
		Ослын цахилгааны эх үүсвэр		
		Аянга зайлуулагч, газардуулга		
7	Тусгай шаардлага	1.		
		2.		
		3.		

Гурав. Ерөнхий дүгнэлт

Зөвшөөрсөн сар, өдөр	Зөвшөөрлийн тэмдэг дарсан хуудасны дугаарууд	Нэмэлт тэмдэглэл

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

.....аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн гал түймрийн улсын хяналтын /ахлах / байцаагч:

.....цолтой /...../ /тэмдэг/

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
 2021 оны 17-дугаар сарын 27-ны өдрийн
 А/154 дугаар тушаалын дөрөвдүгээр хэвсрэлт



БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨЛ ХЯНАЛТЫН БОЛОН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССТ АЖИЛЛАХ ЧИГ ҮҮРГИЙН ХУВААРЬ

Д/д	Онцгой байдлын ерөнхий газар	Төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс
Нэг. Барилгын зураг төслийн хяналт шалгалт		
1.1.	Цөмийн болон дулааны цахилгаан станц, усан цахилгаан станц, төмөр зам, нийсэх онгоцны буудал, метро, улс дамнасан нефть болон хийн хоолой зэрэг улсын стратегийн чанартай барилга байгууламжийн зураг төсөл	Бага, дунд төвөгшилтэй барилга байгууламжийн зураг төсөл
1.2.	Гал түймрийн онц аюултай барилга байгууламжууд, 10001 м ³ дээш эзэлхүүнтэй 6-аас дээш давхар барилга байгууламжийн зураг төсөл	Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт баригдах 10000м ³ -ээс дээш эзэлхүүнтэй, 6-аас дээш давхар, гал түймрийн онц аюултай барилга, байгууламжаас бусад бүх барилга байгууламжийн зураг төсөл
1.3.	Төв суурин газруудыг хот байгуулалтын баримт бичиг боловсруулалт, ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл	Аймаг, нийслэлийн сум, дүүргийн байгуулалтын баримт бичиг боловсруулалт, ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл
1.4.	Улсын болон бүс нутгийн чанартай уул, уурхайн ашиглалт, олборлолт, боловсруулалтын үйлдвэр тэдгээрийн дагалдах барилга байгууламжийн зураг төсөл	Орон нутгийн чанартай уул уурхайн барилга байгууламжийн зураг төсөл
Хоёр. Барилга байгууламжийн ашиглалт оруулах чиглэлээр		
2.1.	Цөмийн болон дулааны цахилгаан станц, усан цахилгаан станц, төмөр зам, нийсэх онгоцны буудал, метро, улс дамнасан нефть болон хийн хоолой зэрэг улсын стратегийн чанартай барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд ажиллах.	Үйлчлэх хүрээ нь орон нутгийн шинж чанартай барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд ажиллах.
2.2.	Төв, орон нутагт гал түймрийн онц аюултай барилга байгууламжууд, 10001 м ³ дээш эзэлхүүнтэй 6-аас дээш давхар барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд ажиллах.	Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт баригдсан 10000м ³ -ээс дээш эзэлхүүнтэй, 6-аас дээш давхар, гал түймрийн онц аюултай барилга, байгууламжаас бусад бүх барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд ажиллах.

2.3.	Барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зохион байгуулсан улсын комиссын бүрэлдэхүүнд гишүүнээр томилогдсон тохиолдолд ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд ажиллах.	Орон нутгийн хэмжээнд барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд ажиллах.
2.4.	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зохион байгуулсан улсын комиссын бүрэлдэхүүнд гишүүнээр томилогдсон тохиолдолд ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд ажиллах.	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зохион байгуулсан улсын комиссоос бусад ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд ажиллах.
2.5.	Шинээр баригдаж байгаа гал түймрийн онц аюултай барилга байгууламжийн галын аюулгүй байдалд батлагдсан удирдамжаар явцын хяналт тавих.	Шинээр баригдаж байгаа барилга байгууламжийн галын аюулгүй байдалд явцын хяналт тавих болон бүх төрлийн барилга байгууламжийн их болон урсгал засварын ажлыг ашиглалтад оруулах.

---oOo---